

Ипотекийн зээлийн тайлан

2014 оны 12 дугаар сар


Банкууд 2014 оны 12 дугаар сард нийт 1963 зээлдэгчид 108.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2844.6¹ тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 66334-т хүрчээ.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 3.9 нэгж хувиар, оны эхнээс 82.7 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” (ОСИСТТБХ)-ийн хэрэгжилттэй холбоотойгоор 2013 оноос эхлэн эрс нэмэгдсэн байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь



*2014 оны 12-р сарын ипотекийн зээлийн үлдэгдлийг 2014 оны III улирлын нэрлэсэн ДНБ-д харьцуулсан.


Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.3 хувь буюу 2027.9 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 26.3 хувь буюу 747.4 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 2.4 хувь буюу 69.4 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



¹ МИК-т шилжүүлсэн зээлийн дүн орсноор.

2014 оны 12 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.1 хувь нь төгрөгийн зээл, 1.9 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2014 оны 12 дугаар сарын байдлаар 0.9 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.4 байна.



Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 33.5 хувиар өссөн ч оны эхнээс 17.9 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 74.4 хувь буюу 80.7 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн

тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 25.4 хувь буюу 27.6 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2014 оны 12 дугаар сарын байдлаар 55.3 сая төгрөг байна.



Тухайн сард 26.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 12.6 хувиар, оны эхнээс 6.4 хувиар өссөн байна.



Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1963 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1467 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн

тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 490 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд, 6 зээлдэгч бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




2014 оны 12 дугаар сарын байдлаар нийт 66334 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 45283 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 19031 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2020 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.7 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2014 оны 12 дугаар сарын байдлаар 15.3 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 55.7 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 54.8 хувь нь 16-20 жил, 27.1 хувь нь 11-15 жил, 15.1 хувь нь 6-10 жил, 3.0 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Зээлийн хүү

Банкуудын 2014 оны 12 дугаар сард олгосон ипотекийн зээлийн хамгийн өндөр хүү нь жилийн 26.4 хувь, хамгийн бага нь 3.0 хувь байсан бөгөөд тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 9.9 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6.7 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.5 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	Тухайн сард олгосон зээлийн ЖДХҮҮ, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)
			ОСИСТГБ хөтөлбөрийн зээл			
2008	12	217,977.5		100.7	19.8	16,522
2009	12	226,040.6		103.4	18.7	16,784
2010	12	333,776.6		115.0	16.0	19,700
2011	12	669,662.8		154.3	14.8	26,869
2012	12	845,204.4		155.5	15.3	29,887
2013	1	856,633.6		149.1	17.0	29,683
	2	873,666.4		156.1	16.8	29,946
	3	903,557.5		158.6	15.7	30,419
	4	944,516.8		155.4	15.8	31,412
	5	986,182.2		147.8	16.6	32,247
	6	1,032,156.7	276,328.4	168.3	12.9	33,028
	7	1,273,003.6	553,346.9	202.4	9.2	37,751
	8	1,461,753.4	781,483.2	207.6	8.9	40,596
	9	1,611,383.8	943,976.7	206.0	9.1	42,968
	10	1,750,781.6	1,076,924.5	193.9	9.6	45,138
	11	1,834,042.7	1,155,409.2	192.8	9.7	46,482
	12	1,938,945.3	1,248,633.8	192.8	9.9	48,320
2014	1	2,021,424.9	1,324,898.9	194.4	9.8	49,731
	2	2,121,802.6	1,382,084.1	193.2	9.9	53,611
	3	2,193,368.6	1,451,938.1	190.7	9.9	54,787
	4	2,280,503.5	1,538,506.8	192.1	9.8	56,137
	5	2,365,349.5	1,618,127.2	189.3	10.0	57,579
	6	2,440,007.1	1,684,583.9	182.3	10.5	58,793
	7	2,492,105.2	1,728,222.8	187.9	10.7	59,756
	8	2,553,827.2	1,780,078.3	186.7	10.5	60,851
	9	2,619,161.1	1,833,494.0	185.9	10.6	62,017
	10	2,703,792.6	1,903,636.6	189.3	10.4	63,652
	11	2,762,633.1	1,954,247.6	194.5	10.3	64,577
	12	2,844,612.6	2,027,859.2	200.1	9.9	66,334

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2014 оны 11 дүгээр сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь			
1 Улаанбаатар	2,131,004.0	77.1%	1,470,731.5	75.3%	196.4	10.4	44352
2 Дархан-Уул	100,712.0	3.6%	85,277.7	4.4%	195.8	11.0	2163
3 Орхон	96,064.3	3.5%	81,215.3	4.2%	178.9	9.9	2643
4 Дорноговь	57,109.5	2.1%	44,215.8	2.3%	189.1	10.6	1718
5 Сэлэнгэ	40,116.0	1.5%	31,009.7	1.6%	200.1	10.2	1413
6 Дорнод	35,628.8	1.3%	31,270.3	1.6%	197.8	8.7	1251
7 Өвөрхангай	33,958.8	1.2%	23,459.8	1.2%	169.6	9.9	1272
8 Увс	32,748.1	1.2%	21,758.8	1.1%	208.6	9.4	1184
9 Өмнөговь	30,740.9	1.1%	20,878.8	1.1%	200.3	10.5	891
10 Баянхонгор	30,042.5	1.1%	26,402.7	1.4%	215.0	8.2	932
11 Ховд	24,117.2	0.9%	19,194.6	1.0%	163.4	10.1	913
12 Баян-Өлгий	19,004.2	0.7%	8,851.0	0.5%	201.8	9.3	988
13 Сүхбаатар	18,544.6	0.7%	12,002.9	0.6%	169.4	10.1	698
14 Архангай	16,791.4	0.6%	12,544.5	0.6%	173.7	7.1	544
15 Говь-Алтай	15,462.8	0.6%	12,318.4	0.6%	207.7	8.0	536
16 Завхан	14,176.6	0.5%	8,255.2	0.4%	160.8	10.3	593
17 Хөвсгөл	14,080.6	0.5%	6,755.3	0.3%	111.7	18.5	628
18 Дундговь	11,205.4	0.4%	8,770.6	0.4%	158.4	8.4	360
19 Төв	10,790.1	0.4%	7,565.5	0.4%	214.8	7.7	384
20 Говьсүмбэр	10,640.5	0.4%	9,588.5	0.5%	178.3	10.8	365
21 Булган	10,139.8	0.4%	5,064.2	0.3%	221.6	12.2	397
22 Хэнтий	9,554.9	0.3%	7,116.6	0.4%	230.4	9.0	352
Нийт	2,762,633.1	100%	1,954,247.6	100%	194.5	10.3	64577

2014 оны 11 дүгээр сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.1 хувийг Улаанбаатар хотод, 22.9 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 15.9 хувь буюу 100.7 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 15.2 хувь буюу 96.1 тэрбум төгрөг Орхон аймагт, 9.0 хувь буюу 57.1 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.